**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛ**

*/2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/*

2024 оны 12 дугаар сарын 15 — Дархан

## НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**ЗОРИЛГО: Нийгмийн бодлогын салбарын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ**

| Д/д | ЗДҮАХ-ын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/ | Зорилтот түвшин, үр дүн /Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он: Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн /Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он: Хүрсэн түвшин, үр дүн /Хэрэгжилт/ | % тухайн жилээр | % 4 жилээр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **1.1 ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | |
| **ЗОРИЛГО 1.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлнэ. /"Алсын хараа-2050"-ийн 2.2.5, ЗГҮАХ-2.1.1/** | | | | | | | | |
| **Зорилт:1.1.1.1.** Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 1 | Иргэдийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж, амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах | 2021-2024 | ЭМГ | ЗДҮАХ 3.8 сая | Танхимын сургалт 500, цахим сургалт 600 | "Эмэгтэйчүүдийн хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэх амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан "Ягаан тууз" сургалт өдөрлөгийг 1-16, Өргөө, Малчин багийн 815 эмэгтэйчүүдийг хамрууллаа.<br>**Үр дүн:** Эмэгтэйчүүд хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг давхардсан тоогоор 1211 эмэгтэйчүүдэд хүргэлээ.<br>Халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийг бууруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор зөвөлгөөнийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтэн 36 хүн оролцсон ба мэдээлэл,зөвөлгөө, сэрэмжлүүллийг цахимаар 14522 хүнд хүргэсэн. Эрсдэл бүлэгт чиглэсэн БЗДХ,ХДХВ,ДОХ-оос сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулж 1122 иргэд хамрагдсан. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр Эрүүл мэндийн байгууллагууд, Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг хамтран нус цэрэг ил задгай хаяхгүй байх, зөв ханиаж найтаах Дархан зах, Их дэлгүүр, Олон улсын худалдааны төв, Номин худалдааны төв, | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үйлчилгээний төв зэрэг томоохон худалдааны газруудын түрээслэгч нар, үйлчлүүлэгч нарт чиглэсэн Эрүүл мэндийн байгууллагууд хуваарилагдсан газарт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 2800 гаруй иргэдэд мэдээлэл өгч, зөвлөмж тарааж ажилласан.<br>Үр дүн: 2021 онд мэдээлэл сурталчилгаанд 104218 хүн, 2022 онд 12251, 2023 онд 4353 хүн, 2024 онд 22833 хүнд мэдээлэл хүргэж ажилласан байна. | | |
| 2 | "Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ, ОБГ, Цагдаагийн газар | - | Осол гэмтлийн тохиолдол буурсан байна. | Миний гэр аюулгүй орчин эрсдэлийн үнэлгээнд 150 өрхийн 400 иргэн оролцсон.<br><br>Хүүхдийн тоглоомын талбай MNS6751:2019 ерөнхий шаардлага, стандартын дагуу хэрэгжилтийг хангах эсэхэд хяналт, тавьж, зөрчил дутагдлыг арилгах, зөвлөн, туслах, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийтийн эзэмшлийн газрын хүүхдийн тоглоомынталбайг шалгах хяналтын удирдамжийн дагууДархан хотын соёл амралтын хүрээлэн, Дархан хотын хот тохижилтын газартай хамтран тоглоомын талбайн эдрэл гэмтэл, бүрэн бүтэн байдал хяналт шалгалтыг ажлыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд 26 хамтарсан баг 9 чиглэлээр хамтарсан үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалтыг 2024 оны 9-11 сард хийж гүйцэтгэсэн, 26 дүгнэлт, 1 зөвлөмж, 26 албан шаардлага хүргүүлж, ерөнхий дүгнэлтийг Дархан сумын ИТХ хүргүүлсэн. Такси үйлчилгээ үзүүлдэг жолооч нарт "Би хүүхдэдээлтэй хариуцлагатай жолооч" арга хэмжээг "Элит хөгжил" ХХК, "Шар зам хоршоо", Дархан UBcab зэрэг такси үйлчилгээ үзүүлдэг 3 байгууллагын 106 жолооч хамрагдлаа.<br><br>Сургалтад хамрагдсан жолооч нар "Би хүүхдэд ээлтэй хариуцлагатай жолооч" наадаг тэмдэглэгээг автомашин дээрээ нааж, дээрх стикер нааж, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br><br>**Үр дүн:** Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх, нөлөөлөл, сурталчилгааны ажил, 6 удаа, аюулгүй орчин үнэлгээ 2 удаа тус | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус зохион байгуулснаар эцэг эх, гэр бүлд чиглэсэн сургалтад 5764 хүн буюу эцэг эх, асран хамгаалагчдын 20 хувийг хамруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалын "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх", "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх" журмын дагуу 760 хүүхдэд 18.401.675 төгрөгийн шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн. | | |
| **Зорилт: 1.1.1.2.** Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 3 | "Халдварт болон халдварт бус өвчинтэй тэмцэх" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ ӨЭМТ | | Халдварт өвчний тархалт буурна. | **2021** онд МУЗГын Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, Халдварт бус өвчинтэй тэмцэх, Хүн амын хоол тэжээл, Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эрүүл шүд-эрүүл хүүхэд, Осол гэмтлээс сэргийлэх, Эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөр, шинээр батлагдсан Хавдрын эсрэг, харшлын эсрэг 2 арга хэмжээний төлөвлөгөө, Давсны хэрэглээг бууруулах стратеги хэрэгжиж, хэрэгжилтийн дундаж хувь 91.4%-тай байна. **2022** онд Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого" болон үндэсний хөтөлбөрүүдийг хүчингүй болгосон. Уг тогтоолын дагуу Дархан-Уул аймагт хэрэгжиж байсан 7 үндэсний хөтөлбөр хүчингүй болж арга хэмжээний төлөвлөгөө болон хэрэгжүүлж байна. Үр дүн: Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 6 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт **93,4%**-тай байна. Эрүүл Дарханчууд аймгийн дэд хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт нь **96.76%**<br><br>**2023** онд "Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Элэг бүтэн Монгол", "Орчны эрүүл мэнд" "Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх", "Эрүүл шүд" зэрэг зорилтот бүлгийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих 9 арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн дундаж **95%** байна. **2024** он: "Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Элэг бүтэн Монгол", "Орчны эрүүл мэнд" "Халдварт арга өвчинтэй тэмцэх сэргийлэх", "Эрүүл шүд" зэрэг зорилтот бүлгийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих 9 арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн дундаж **98.6% байна**. 2024-2027 онд хэрэгжүүлэх Сэтгэцийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгаалал, Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх, сэргийлэх, Иргэний эрүүл мэндийн боловсрол зэрэг 5 арга хэмжээний төлөвлөгөө шинээр батлагдан ирсэн.<br><br>**Үр дүн:** 2021-2024 оны 4 жилд хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт **91.4%-иас 98.6%** болж 7,2 хувиар нэмэгдсэн байна. | | |
| 4 | "Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | - | Хорт хавдраар шинээр өвчлөгчдийн тоо буурна. | Хавдрын тухай ойлголт, хавдраас урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад 36524 иргэн хамрагдаж, 6 төрлийн зөвлөмж, 3 төрлийн шторкыг орон нутгийн 3 телевиз, 2 радиогоор өдөр бүр 36-42 удаагийн давтамжтайгаар сурталчилж ажиллаж байна. Хавдрын эмчийн амбулаторийн үзлэг-2936.<br>Хорт хавдрын шинэ тохиолдлын тоо-153. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор буурсан байна. Хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын тоо-101. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 тохиолдлоор буурсан байна. Хорт хавдрын шинэ тохиолдлын 13.1 хувь нь эрт үедээ, 86.9 хувь нь хожуу үедээ оношлогдсон.<br>Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны нийт 33529 эмэгтэй хамрагдахаас 17515 эмэгтэй буюу 72.6%-ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.5 хувиар буурсан байна.<br>Элэгний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 40-65 насны нийт 28461 иргэн хамрагдахаас 26762 буюу 94.0% хамрагдсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар өссөн байна.<br>Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт 7703 эмэгтэй хамрагдахаас 3043 буюу 39.5%-ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.1 хувиар буурсан байна. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Иргэдийг эрт илрүүлэг, үзлэг оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулна. | 2021-2024 | ЭМГ ӨЭМТ | ОНТ 1.0 сая | 7500 иргэн үзлэгт хамрагдсан байна. | 2023 онд 3670 оюутан залуучуудыг 10 удаагийн давтамжтай БЗДХ, ХДХВ/ДОХ-ын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 15 шинэ тохиолдлыг илрүүлэн, эмчлэн эрүүлжүүлсэн.<br><br>Өсвөр үе, оюутан залуучуудад эрүүл мэндийн зөвлөгөөг кабинетаар болон утсаар нийт зорилтот бүлгийн 127 залуучуудад үзүүлсэн. Мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээнд 86 хүүхдийг хамруулж, эрүүл мэндийн тусламж үзүүлсэн байна.<br><br>Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 18-30 хүртэлх насны 3768 оюутан залуус, 6-17 насны 17630 хүүхэд хамрагдсан байна.<br><br>**Үр дүн:** Өсөн дүнгээр хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 18-30 хүртэлх насны 3768 оюутан залуус, 6-17 насны 17630 хүүхэд хамрагдсан байна. | 100% | 100% |
| **Зорилт: 1.1.1.3.** Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | | | | | | | | |
| 6 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХОХБТХ, ОНӨГ, ЭМГ | ОНХСХО 5.0 сая | Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж хангагдана. | Өрхийн эрүүл мэндийг төвийн үйл ажиллагааг дэмжих сургалт зохион байгуулах таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн "ГОС ХОТ" өрхийн эрүүл мэндийн төвийн Сургалтын танхим тохижуулсан.<br><br>**Үр дүн:** Төсөл хэрэгжсэнээр 1-8, Өргөө, Малчин багийн 44,244 иргэнд сургалт мэдээлэл өгөх орчин нөхцөл бүрдсэн. | 100% | 100% |
| **Зорилт 1.1.1.4.** Орчин үеийн техник, технологитой "Оношлогоо эмчилгээний төв" байгуулж, гуравдугаар шатлалын эмнэлэг рүү явах иргэдийн урсгалыг бууруулна. | | | | | | | | |
| 7 | Төвийн бусийн оношлогоо эмчилгээний төвийг байгуулж, үйл ажиллагаа эхлүүлэх. | 2022-2024 | ЭМГ | 12 000 сая /УТХО | Иргэд чирэгдэлгүй эрүүл мэндийн үйлчилгээг авна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутагт "Оношилгоо, эмчилгээний төв" байгуулах саналыг 2021 онд Эрүүл яаманд санал хүргүүлсэн боловч бүсийн хэмжээнд Орхон аймагт байгаа учир дэмжигдээгүй. 2022 онд Дархан-Уул аймагт шинээр эмнэлэг байгуулахад Европын сэргээн босголтын банкны шинжээч аудиторын баг ирж ажилласан<br><br>Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Дархан-Уул аймгийн хүн ам механикаар 20% өсөж 2024 онд 127.0 | 70% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мянган хүн амтай байхаар тооцоо гарсан. Иймд орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Европын сэргээлт босголт банкны санхүүжилтээр Дархан-Уул аймагт шинэ жишиг Нэгдсэн эмнэлэг барих төслийн хүрээнд барилгын нийт талбай 29841м2 хүртэл, хэвтэн эмчлүүлэх орны тоо 250, нийт 33 үндсэн нэгжтэй байх саналыг аймгийн Засаг даргын 2023 оны 1-10/709 дугаар албан бичгээр Европын сэргээлт босголт банканд хүргүүлсэн. | | |
| 8 | Зоонозын төвийн харьяа нэгж байгуулах | 2021-2024 | ЭМГ | Улсын төсөв 250.0 сая | Зоонозын нэгж байгуулах | Зоонозын Өвчин Судлалын Төв /цаашид ЗӨСТ гэх/-ийн барилга нь аймгийн төвүүдэд байгуулах барилгын нэг маягийн зураг төслөөр баригдахаар болсон бөгөөд 2023 оны УТХО-нд Дархан-Уул аймагт баригдах ЗӨСТ-ийн барилгын холболтын зураг, төсвийн 25.8 сая төгрөг батлагдсан.<br><br>Иймд ЗӨСТ-ийн барилга барих газрыг Дархан сумын 13-р баг, Үйлдвэрчний 2-р гудамж 203А байршилд аймгийн Засаг даргын 2023 оны А/280 дугаар захирамжаар 3000м2 газрыг ЭМГ-ын нэр дээр олгосон. Олгогдсон газарт барилгын холболтын зураг хийхэд шаардлагатай зургийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулж ЭМЯ-д хүргүүлэн, тус яамнаас тендер зарлуулахаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Мөн техникийн нөхцөлийг ЭМЯ-нд хүргүүлсэн. | 30% | 30% |
| **Зорилт: 1.1.1.5.** Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 9 | Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг барих ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | Улсын төсөв 214.0 сая | Амин холбоо ӨЭМТ-ийн өргөтгөл хийх | Амин холбоо өрхийн эмнэлэгт 2025 онд өргөтгөл хийхээр АЗДТГ-т хүсэлт хүргүүлж 2025 оны улсын төсөвт суугдсан. | 70% | 70% |
| **Зорилт: 1.1.1.6.** "Шилэн эмнэлэг-II" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 10 | "Шилэн эмнэлэг" төслийг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | УТ, ОНТ 10.0 сая | Эмнэлгийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, | 2023 онд "Шилэн эмнэлэг" /"Цахим Монгол" ЗГ-ын мөрийн хөтөлбөр/ төслийг өрх болон сумын эрүүл мэндийн төвүүдэд хэрэгжүүлэхээр Найрамдал Дархан төслийн хүрээнд ICT группээс 5 өрхийн эрүүл мэндийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээгдэлгүй авах нөхцөл бүрдэнэ. | төвүүдэд цаг авах тоног төхөөрөмж киоск, дэлгэцийн хамт суурилуулж иргэдэд цаг олгож байна. Мөн төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлэгт цаг авах, шинжилгээний хариу авах киоск төхөөрөмж суурилуулсан | | |
| ЗОРИЛГО 1.1.2. **Эрүүл идэвхтэй амьдралыг** дэмжих эрүүл **мэндийн хөтөлбөрүүдийг** хэрэгжүүлнэ. /**"Алсын хараа-2050"-ийн 2.2, ЗГҮАХ-2.1.1.1, 2.1.1.3/** | | | | | | | | |
| **Зорилт: 1.1.2.1.** "Эрүүл Дарханчууд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 1<br>1 | "Эрүүл Дарханчууд" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | УТХО<br>165.0 сая<br><br>ОНХС<br>20.0 сая<br><br>ОНХС<br>16.0 сая | Нийт өвчлөл буурсан байна. | Эрүүл мэндийг дэмжих төвд улсын төсвийн 1850.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн засвар үйлчилгээг хийж нийт 34 нэр төрлийн 95 ширхэг 796.1 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авч суурилуулсан. "Илүүдэл жингүй-Эрүүл монгол" идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аянд 1-16, Өргөө, Малчин багууд, Засаг даргын Тамгын газрын нийт-80 албан хаагчийг товлосон хугацаанд хамруулан ажиллаж байна. Нэгдсэн эмнэлэг эмгэг судлалын тасгийн ёслолын өргөө, арын өрөөний дотор засварын ажил 20 сая төгрөгийн төслийг дэмжин санхүүжилтийг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд эмэгтэйчүүдийн үзлэгийн орыг Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт хүлээлгэн өглөө. Урьдчилан сэргийлэх үзлэг 90% Өвчлөлийн 10.1 хувиарь буурсан | 90% | 90% |
| 1<br>2 | "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ | - | Өвчлөл буурсан байна | Хавдар судлалын үндэсний төвөөс Хөнгөвчлөх эмчилгээ, өвдөлт намдаах тусламжийн сургалт зохион байгуулж, 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Монгол орон даяар үндэсний хэмжээнд "Амьдрал бэлэг" төслийн хүрээнд элгээ хайрладаг хүн бүрд зориулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж, 200 гаруй иргэдийг, Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 48 удаагийн сургалтаар 13571 хүнд сургалт зохион байгуулсан. Эмчийн ярилцлага-3 удаа, мэдээлэл 7 удаа, эрүүл мэндийн цахим зөвлөгөө ярилцлага-6 удаа тус тус бэлтгэн иргэдэд түгээсэн. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвөөс боловсруулсан 17 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийн 14 сувгаар түгээсэн. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хандалтын тоо-35411 хүн, хөнгөвчлөхийн тасагт 387 хүн хэвтэн эмчлүүлсэн байна. | | |
| 13 | "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЭМГ Хувийн эмнэлэг | - | Хүүхдийн үзлэгт хамрагдалтын тоо өссөн байна. | 2022 онд 2-12 насны 9622 хүүхэд Нэгдсэн эмнэлэгт, 16469 хүүхэд хувийн эмнэлэгт урьдчилан сэргийлэх шүдний үзлэгт хамрагдаж, өвчлөл 5471 бүртгэгдэж, эмчлүүлсэн. Шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 18758 эцэг эхчүүдэд сургалт мэдээлэл зохион байгуулсан. | 100% | 100% |
| **1.2. БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | | | | |
| **ЗОРИЛГО 1.2.1.** Хүн амыг **хөдөлгөөний дутагдлаас урьдчилан** сэргийлж, **нийтийн биеийн тамир, спортын хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ-2.2.1, АХҮЧ-3.5.3/** | | | | | | | | |
| **Зорилт: 1.2.1.1.** Олон улсын болон улсын чанартай спортын тэмцээн уралдаанд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | | |
| 14 | Монгол улсын нэрийг тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | БТСГ | ЗДНХ 12.0 сая<br><br>ЗДНХ 1.0 сая | Уралдаан тэмцээний зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Дархан 88 олон улсын дугуйн тэмцээнийг "Дархан дугуйн холбоо"-той хамтран зохион байгуулж тус тэмцээнд 12-75 насны ангилалд 50 гаруй клубийн 400 орчим тамирчид оролцлоо. Ахмад тамирчин Дашдоржийн Батчимэг, Пүвсанчимэдийн Алтангэрэл нарт Ази номхон далайн орнуудын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд багаараа Алтан медаль хүртэж амжилттай оролцлоо. **Үр дүн:** Олон улсын, улсын чанартай тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж Дархан суманд нутагшуулах, биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2.818 км стандартын дугуйн замтай болсон. | 100% | 100% |
| **Зорилт: 1.2.1.2.** Хүн амын зорилтот бүлгүүдэд /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ чиглэсэн биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжинэ. | | | | | | | | |
| 15 | Ахмадуудын спортын их наадмыг спортын 5 төрлөөр зохион байгуулна. | 2021-2024 | БТСГ | ЗДҮАХ 10.0 сая | Спортын наадамд оролцогчдын тоог 1,5 хувиар нэмэгдүүлэх | Ахмадуудын спортын 5-р наадмыг 10-р сарын 7- 8 өдрүүдэд спортын 6 төрөл /дартс, граунд гольф, софт волейбол, шатар , ширээний теннис, бадминтон / - оор амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын 21 багийн 380 гаруй тамирчид 2 насны ангилалд өрсөлдөж багийн нийлбэр дүнгээр Дархан сумын 8-р баг ТЭРГҮҮН байр, Дархан сумын 10-р баг ДЭД байр, Дархан сумын 16-р баг ГУТГААР байранд тус тус шалгарлаа. Тэмцээний зардалд улсын төсвөөс 4 сая төгрөг зарцуулсан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ахмад настны хөгжил хамгаалал, биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд ахмадуудын дунд 10 төрөлт Соёл, Спортын аварга шалгаруулах тэмцээнийг Дархан сумын ахмадын хороотой хамтран зохион байгууллаа.<br><br>**Үр дүн**: Дархан суманд 55-аас дээш насны 12760 ахмадуудаас 2022 онд 528 хүн , 2023 онд 670 хүн буюу 9.3%-аар биеийн тамираар хичээллэх ахмад настнуудын тоо нэмэгдсэн. Биеийн тамираар тогтмол хичээллэгч ахмадуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Дархан спортын ордонд 2,4 өдрүүдэд өдөрт 2 цаг гарган үнэ төлбөргүй хичээллүүлж байна. | | |
| 1<br>6 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | БТСГ | БТСГ<br>0.3 сая<br>ЗДНХ<br>2.5 сая | ХБИ-ийн нийгмийн оролцоо нэмэгдсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд жил бүр уламжлал болгон явагддаг "Бид хамтдаа" арга хэмжээний хүрээнд "Пара хөнгөн атлетикийн, нисдэг таваг, дартс зэрэг төрлүүдээр насанд хүрэгч өсвөр үе гэсэн 2 ангиллаар зохион байгуулж 70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдлаа улсын төсвөөс 1 сая төгрөгөөр зохион байгуулсан . ХБИ- нь пара хөнгөн атлетикийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 тамирчин эрэгтэй 10, эмэгтэй 10 төрөл /хараны бэрхшээлтэй, нуруу нугасны бэрхшээлтэй, гар, хөлийн тайралттай, одой гэсэн ангиллаар оролцож орон нутгаас 2 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлэн оролцуулсан.<br><br>7 дугаар цэцэрлэг нь тусгай хэрэгцээт ТЭМҮҮЛЭЛ-1, 2 бүлгийн хүүхдүүдийн дунд "БИ ЧАДНА" спорт өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгт тусгай хэрэгцээт 45 хүүхэд эцэг, эхчүүд, багш нар оролцлоо. Тус арга хэмжээний үеэр хүүхэд багачуудын бие бялдрын боловсролыг дэмжихэд шаардагдах 700.000 төгрөгийн хэрэглэл материалын дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа.<br><br>Тэргэнцэртэй, хөдөлгөөний хязгаарлалтай иргэдийн идэвхийг өрнүүлэх, нөхөрсөг харилцааг эрхэмлэн спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Туялзуур сэлэм"-ний тэмцээнийг Дархан Уул аймгийн тэргэнцэртэй иргэдийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоо ТББ-тай хамтран амжилттай зохион байгууллаа. **Үр дүн :** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан арга хэмжээнд оролцогчдын тоо 2,5-3,5 хувьд хүрж 1 хувиар өссөн /4500орчим хүнээс 170 хүн оролцож байна. | | |
| Зорилт: **1.2.1.3.** Нийтийн биеийн тамирыг үе шаттайгаар хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 17 | Гэр бүл, иргэдийн оролцоотой тэмцээн уралдаан зохион байгуулна. | 2021-2024 | БТСГ | ОНТХО 0.3 сая | Иргэдийн эрүүл, идэвхтэй амьдрах хэв маяг сайжирна. | "Илүүдэл жингүй эрт эч Монгол" аян, цасны баяр, ажлын байрны дасгал, өглөөний дасгал, завсарлагааны дасгал, дугуйн баяр, дугуйтай дархан арга хэмжээ, тамирчдын өдөр зэрэг иргэн , гэр бүл хамт олныг хамруулсан арга хэмжээг жил бүр зохион байгуулж байна. Мөн шинээр санаачлан " Эрүүл амьдрал –Идэвхтэй хөдөлгөөндөө цаг гаргая" аяныг 3 дугаар сарын 01-ны өдрөөс 6-р сарын 24 хүртэл Дархан-Уул аймгийн гэр бүл , албан байгууллага , аж ахуй нэгж, оюутан залуучууд, хүүхдүүдийн дунд өрнүүллээ. "ЦАГ ГАРГАЯ " аяныг зохион байгуулж 12368 хүн хамрагдлаа. Энэ аяны хүрээнд нийт 7 спорт заал, 3 фитнесс клуб, 6 гадаа талбай, 3 клуб, 36 чийрэгжүүлэх танхим, 1 сөлын төв, 1 усан бассейнаар иргэдэд үйлчилүүлээ. Аяны хүрээнд аймгийн хэмжээний 86 байгууллага , их дээд болон ерөнхий боловсролын сургууль, СӨББ байгууллага, гэр бүл, иргэд 7 хоног бүрийн баасан , бямба гаригийн өглөө тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлсэн байна. Мөн аяны хүрээнд зохион байгуулсан бүх нийтийн марафон, Бүх нийтийн алхалт , цахим гиминастик , дугуйн арга хэмжээ зэрэг биеийн тамирын арга хэмжээнд 5300 гаруй хүн хамрагдсан байна.<br>Мөн Дархан хотын өдөрт зориулсан биеийн тамир, спортын 4 арга хэмжээд мянга гаруй иргэн хамрагдлаа орон нутгийн төсвөөс 10 сая төгрөг зарцуулсан.<br><br>**Үр дүн:** Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо нийт хүн амын20 %-23.0% -ийг ээлдэг болж нэмэгдсэн. Мөн нийтийн биеийн тамирын арга хэмжээний зардал 2020 онд 27,412,650₮ буюу 1 хүнд | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 263 төгрөг ноогдож байсан бол 2023улсын төсвөөс 32сая, орон нутгаас 20сая төгрөг зарцуулдаг болж нэг хүнд 500 орчим төгрөг ноогдож байна. | | |
| **Зорилт: 1.2.1.4.** Өвлийн спортыг хөгжүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 18 | Өвлийн спортын ордон байгуулна. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | - | Хүүхэд залуусыг өвлийн спортоор хичээллэх орчин нөхцөл бий болно. | Өвлийн спортын ордоны зураг төсвийг гаргаж, газрын асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр санхүүжилт суугдсан. | 70% | 70% |
| 19 | Өвлийн спортыг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | ЗДНХ 1.0 сая | Эрүүл чийрэг хүүхэд, залуусын тоо нэмэгдэнэ. | Өвлийн спортыг хөгжүүлэхээр улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулсан. Үүнд "Болд" сангийн нэрэмжит тэмцээнд 7 багийн 100 тамирчид, МХХ цомын төлөө U-12 насны аварга шалгаруулах 5 багийн 70 тамирчид, Өсвөр үеийн хоккейчдын 14 насны улсын аварга тэмцээнд 6 багийн 80 тамирчин оролцлоо. Монголын Хүүхдийн спортын Өвлийн 7-р их наадмын "Гүйлтийн цана"-ын төрөлд түс сумын баг тамирчид амжилттай оролцож 2 Алтан медаль,1 мөнгөн медаль хүртлээ. | 100% | 100% |
| **ЗОРИЛГО 1.2.2. Үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх бодлого баримтална. /ЗГҮАХ-2.2.2/** | | | | | | | | |
| **Зорилт: 1.2.2.1.** Үндэсний спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо клубуудыг дэмжих ажиллана. | | | | | | | | |
| 20 | Үндэсний спортын наадамд тамирчдыг амжилттай бэлтгэн оролцуулах. | 2021-2024 | СЗДТГ, БТСГ | УТХО<br>0.6 сая | Баг тамирчдыг бэлтгэл сургуулилтыг чанартай хийх боломж нөхцөлөөр хангах | Үндэсний спортын наадмын шигшээ тэмцээний өвлийн 2 төрөлд 16 тамирчин оролцсон. Мэсний шагайн төрөлд 1 хүрэл медаль хүртсэн амжилттай явж байна. Зуны 9 төрөлд оролцох тамирчид бэлтгэл сургуулилтаа хангаж байна.<br><br>Үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх зорилгоор "Дархан Үндэсний цэц харваа" ТББ 19.5 сая төгрөгийн өртөгтэйгээр зурхайн зогсоолын тохижилтын ажил 100% гүйцэтгэлтэй хийгдэж, хүлээн авч үндэсний сурын спортоор хичээллэх тамирчдын орчин нөхцөл сайжирсан. **Үр дүн:** Мэсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээнд төрөлд 1 тамирчин хүрэл медаль хүртсэн. | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 1.2.3. Спортын барилга байгууламжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ-2.2.3, 1.6.17, 1.6.22, АХҮЧ-3.5.2/** | | | | | | | |
| **Зорилт: 1.2.3.1.** "Хуучин Дархан-Спорт цогцолбор"-той болно. | | | | | | | |
| 21 | Хуучин Дархан спорт цогцолбор байгуулна. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | УТХО 3.5 тэрбум | Барилгын ажил дууссан байна | Иргэдийн санал санаачилгыг дэмжин хуучин Дарханд Спортын ордныг "Хөшиг-Уул" ХХК-ийн 3.5 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн. Дархан спортын ордон үйл ажиллагаа явуулж эхэлсэн. | 100% | 100% |
| **Зорилт: 1.2.3.2.** Олон Улсын стандартад нийцсэн Хөл бөмбөгийн талбайг ашиглалтад оруулна. | | | | | | | |
| 22 | Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд ОУ-ын стандартад нийцсэн Хөл бөмбөгийн талбай ашиглалтад оруулна. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | УТХО 1.5 тэрбум | ОУ чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах нөхцөл бүрдэнэ. | Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус сумын 14 дүгээр багт байрлах "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд нийт 8350 м2 талбай, гүйлтийн зам нь 2515 м2, бетон талбай нь 2116 м2, үзэгчдийн суудал болон индэр нь 524 м2 бүхий олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай байгуулагдаж ашиглалтад орсон. Ажлын гүйцэтгэл 100%-тай байна. | 100% | 100% |
| Зорилт: 1.2.3.3. Явган хүний зам болон унадаг дугуйн замыг стандартад нийцүүлэн байгуулна. | | | | | | | |
| 23 | Явган хүний зам болон дугуйн зам байгуулна. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | ОНТ 225.0 сая | 4 км дугуйн замтай болсон байна. | 2023 онд шинэ хорооллын 16 байрнаас шинэ хорооллын арын зам-DBS уулзвараас– Аюулгүйн тойрог хүртэл 2,8 км, Соёл амралтын Дархан-60 цогцолборт 1,58 км, Мобикомын уулзвараас – онгоцны буудал хүртэл 2,7км, АШУИС-аас ШУТИС хүртэл 0,7км, Дархан сумын 5, 6 баг Дархан ЗДТГ-аас Гэгээ дэлгүүр хүртэл 0,85 км, 1,3,5 баг 6 буудлаас МСҮ-ийн хүртэл 1,1км, 1-8 багийг холбосон 0,8км дугуйн замыг тус тус энэ онд хийгдэхээр төлөвлөгдөн хийгдэж байна.<br><br>**Үр дүн:** Нийт 16,13 км явган болон дугуйн зам хийгдсэн. | 100% | 100% |
| **1.3. БОЛОВСРОЛ**<br>**ЗОРИЛГО 1.3.1. Цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ. /ЗГҮАХ-2.3.9, АХҮЧ-2.1.5/** | | | | | | | |
| **Зорилт: 1.3.1.1.** Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангуулна. | | | | | | | |
| | СӨББ, ЕБС-ийн гадна хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх төслийг дэмжиж ажиллана. | 2021-2024 | БСУГ, ЕБС, СӨБ | ОНХС, ЗДҮАХ 133.7 сая | Хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдэнэ. | Дархан сумын Засаг даргын санаачилгаар хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүүхдэд ээлтэй хот болох зорилтын хүрээнд "ИТГЭЛТЭЙ УТАС" төслийг "МЦХ ХК"-тай хамтран хэрэгжүүлж дууслаа. Төсөл хэрэгжсэнээр ЕБС-ийн гар утасгүй сурагчид болон гар утасны нэгж ,цэнэг дууссан,сүлжээ тасрах, байгалийн гамшгийн үед ч гэрийнхэнтэйгээ яаралтай утсаар холбогдох боломжтой болж ерөнхий боловсролын 12 сургуульд байршууллаа.<br>4 дүгээр сургууль Урлагийн танхимын тохижилтыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн тохижууллаа. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | | | | | | "ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖИЛ" болгон зарласантай холбогдуулан тус сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн Засвар шинэчлэлийн ажлыг Японы ЗГ-ын өвсний үндэс төслөөр сургуулийн гадна фасад, цонх, хаалгыг сольж, Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр БШУЯ-аас тэгш хүртээмжтэй боловсрол төслөөр хүүхдийн бие засах газар, тусгай хэрэгцээт хүүхдийн өрөө, гадна шатыг засварлаж, Аймгийн ЗДТГ-аас хүүхдийн иж бүрэн сандал ширээг шинэчилж, заслын ажлыг багш ажилчид болон Политехникийн коллежийн оюутнуудын хамтаар хийж гүйцэтгэлээ.<br>Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 25 дугаар цэцэрлэгийн сапбар бүлгийн халаалтын төслийг дэмжин санхүүжүүлсэн.<br>Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 5 дугаар цэцэрлэгийн шугам хоолойн засвар шинэчлэлийн ажилд дэмжлэг үзүүллээ.<br>Ерөнхий боловсролын 5 сургуульд хог ангилан ялгах хогийн савыг байршууллаа.<br>Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн 4, 5, 6, 10, 13, 15, 16, 24 дугаар цэцэрлэг, Од цогцолбор сургуульд тус тус дээвэр засвар, цахилгааны шугам шилжүүлэх болон цахилгаан шит, тоолуур монтаж засвар дулааны шугам сүлжээний засвар, сургууль цэцэрлэгийн дулаан алдагдлыг бууруулахад шаардагдах төсвийг зарцууллаа. | 100% | 100% |
| **Зорилт: 1.3.1.2.** Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулна | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | СӨББ, ЕБС-уудын анги танхимыг иргэд, ААНБ, ОУБ-н дэмжлэгтэйгээр засаж тохижуулна. | 2021-2024 | БСУГ, ЕБС, СӨБ | ТББ 26.0 сая ОНХС 298.3 сая | Хүүхэд багачуудын сурч хүмүүжих орчин сайжирна | Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн онцлогт тохирсон сургалтын орчны стандартад нийцсэн 7 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг "Автокат" ХХК-аар гүйцэтгүүлж, барилгын зургийг батлуулсан. 2022 оны улсын төсөвт өргөтгөлийн барилгыг барих 2 тэрбум төгрөг төсөвлөгдөж, барилга бариулах нээлттэй тендер зарлагдан "Хөшиг уул" ХХК шалгарч 2022 оны 03 дугаар улиралд барилгын ажил эхлэхээр гэрээ хийгдэж барилгын ажил 60% тай явагдаж байна.<br><br>11 дүгээр цэцэрлэгийн дээвэр, сантехник, гал тогооны иж бүрэн засвар тохижилтын ажлыг бүрэн хийж дуусгалаа.<br>Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Гадаад хэлний кабинет тохижилт, засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.<br>Ерөнхий боловсролын Од цогцолбор сургуулийн гадна шугам хоолон засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Сурагчдын сурах таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд стандартад нийцсэн сурагчийн ширээ 500, сандал 1000 ширхгийг 4, 15, 18 дугаар сургуульд хүлээлгэн өглөө.<br>Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 5, 10, 13 26 дугаар цэцэрлэгийн хүүхэд багачуудад сурах таатай орчин нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд хөгжмөөр дамжуулан урлагийн боловсрол олгох 4 төслийг дэмжин санхүүжүүлсэн.<br>**Үр дүн:** Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 1750, ерөнхий боловсролын сургуулийн 9214 сурагчийн сурах орчин нөхцөл сайжирсан. | 100% | 100% |
| **Зорилт: 1.3.1.3. "Ном", "Авъяас" зэрэг хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 26 | "Авъяас" хөтөлбөрийн хүрээнд дугуйлан секцийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2021-2024 | БСУГ, ЕБС, СӨБ | ОНХС 9.5 сая | Дугуйлан секцэд хамрагдах хүүхдийн тоо өснө. | Хүүхэд хөгжлийн ордны үйл ажиллагааг дэмжин Хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд Хүүхэд хөгжлийн ордонд 9 төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.<br>**Үр дүн:** Дугуйланд секцэд хамрагдах хүүхдийн тоо **5,3% -аар нэмэгдсэн** | 100% | 100% |
| 27 | "Ном" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллана | 2021-2024 | БСУГ, Төв номын сан | ОНХС 7.3 сая | Ном уншигчдын тоо нэмэгдэнэ | 2023 онд 447 нэр төрлийн 672 боть 12 900 180 төгрөгийн номоор фондоо баяжууллаа. Үүнээс: Худалдаагаар 9.000.000 төгрөгийн 261 нэр төрлийн 474 боть ном, Хандиваар 3.900.180 төгрөгийн186 нэр | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрлийн 198 боть, хандиваар 928,800 төгрөгийн 56 нэр төрлийн 73 боть номоор баяжилт хийсэн.<br>**Үр дүн:** Нийт 447 нэр төрлийн 672 боть номоор сан хөмрөгийг баяжуулсан. | | |
| **Зорилт: 1.3.1.4.** ЕБС, СӨБ-ын байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 28 | Өргөө багт шинээр 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг байгуулна. | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | УТХО 1.1 тэрбум | Төрийн өмчийн цэцэрлэг тус багт шинээр бий болсон байна | Шинэ цэцэрлэг нь 2021 оны 10-р сард ашиглалтад орсон. Ингэснээр 20 багш ажилтан, 4 бүлэгт 120 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож үйл ажиллагаа эхэлсэн.<br><br>**Үр дүн:** Хамран сургах тойргийн 135 хүүхэд цэцэрлэгт хамрагдсан. | 100% | 100% |
| 29 | Сургуулийн барилга 480 суудалтай /3-р баг/ | 2021-2024 | Аймгийн ХОХБТХ | УТХО 3.0 тэрбум | Хамран сургалтын хүчин чадал нэмэгдэнэ. | 2022 онд 4 дүгээр сургуулийн 480 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг УТХО 5,2 тэрбум төгрөгийн өртгөөр баригдаж, бүрэн ашиглалтад орсон. Сургуулийн өргөтгөл ашиглалтад орсноор 20 бүлэгт 658 гаруй хүүхэд суралцаж, 3 ээлжээр хичээллэж байсан сургууль 2 ээлжээр хичээлладэг болсон.<br><br>**Үр дүн:** 3 ээлжээр хичээллэж байсан сургууль 2 ээлжээр хичээллэж байна. | 100% | 100% |
| 30 | 15 дугаар багт ахлах сургуулийг ашиглалтад оруулах | 2021-2024 | БСУГ | Азийн хөгжлийн банк 2.5 тэрбум | Сонгон шалгаруулалт хийгдэж барилга угсралтын ажил эхэлнэ. | Дархан сумын 15 дугаар багт 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга УТХО 10,0 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж, ажлын явц 67%-тай үргэлжилж байна.<br><br>**Үр дүн:** 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлын явц 67%-тай үргэлжилж байна. | 70% | 70% |
| **Зорилт:1.3.1.5** Чадварлаг багш" төслийг боловсруулж хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 31 | Чадварлаг багш" төслийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021-2024 | БШУГ | ЗДҮАХ 19.0 сая<br><br>ОНХСХО 99.9 сая | Чадварлаг баг байгуулагдсан | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчныг сайжруулах, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах зорилтын хүрээнд "СӨББ ХӨГЖИЛ-60" хөтөлбөрийг Цэцэрлэгийн эрхлэгч нарын холбоотой хамтран зохион байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүллээ.<br>Багшийн хөгжлийг дэмжих, сургалтын орчин сайжруулах зорилтын хүрээнд Багшийн хөгжлийн төвийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.<br>Үр дүн: Ажлын гүйцэтгэл 100% | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | Сурлага, урлаг, спортоор амжилт гаргасан багшийг урамшуулан дэмжинэ. | 2021-2024 | БШУГ | ОНТ 2.0 сая | Сурлага, урлаг, спортоор амжилт гаргасан багш, сурагчдыг 100% урамшуулна | 2022-2023 оны хичээлийн жилд улсын тэрэлжсэн олимпиадад амжилт гаргасан 9 сурагч, 48 улирал "А" үнэлгээтэй суралцсан 84 сурагч, "Дугуйн арга" улсын олимпиадад амжилттай оролцсон 300 сурагчдыг урамшуулан эрхийн бичгийг гардуулсан. Тус арга хэмжээнд ОНТ 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулсан. Үүнд:<br>2021 онд 20 сурагч, 5 багш 23,5 сая<br>2022 онд 30 сурагч, 6 оюутан, 10 багш 54.5 сая<br>2023 онд 42 сурагч, 13 оюутан, 23 багш 89,0 сая төгрөгийн урамшуулал, тэтгэлэг олгосон.<br>Улсын олимпиадад амжилт гаргасан 8 сурагч, 2 багшид хүндэтгэл үзүүлсэн.<br>**Үр дүн:** Сурлагын амжилт гаргасан ЭЕШ-д амжилт гаргасан 111 суралцагч, 38 багшид 3 жилийн хугацаанд 167,0 сая төгрөгийн урамшуулал 100% олгосон. | 100% | 100% |
| **Зорилт: 1.3.1.5.** Төр иргэний хамтын ажиллагааг сайжруулж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулна. | | | | | | | | |
| 33 | Иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021-2024 | ТББ, холбоод | ЗДҮАХ 10.0 сая | Иргэд мэдээ мэдээллээр хангагдана | Дархан сумын Хэвлэл мэдээллийн албанаас иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд нийгэм рүү чиглэсэн уриалга пост 115 постер, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 106 постер, 256 дүрстэй мэдээ, 241 фото мэдээ, Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 35 постер байршууллаа. | 100% | 100% |
| **1.4. СОЁЛ УРЛАГ**<br>**ЗОРИЛГО 1.4.1. Соёл, урлагийн байгууллагын хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ. /Алсын хараа-2050-ийн 1.1.5, ЗГҮАХ-2.6.2/** | | | | | | | | |
| **Зорилт: 1.4.1.1.** Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ. | | | | | | | | |
| 34 | Соёлын байгууллагуудыг дэмжин ажиллана. | 2021-2024 | ДС ЗДТГ | ОНТХО 5.0 сая<br>ОНХС 7.3 сая | Соёлын байгууллагын үйл ажиллагаа сайжирна | Соёл урлагийн байгууллагыг дэмжих зорилтын хүрээнд Хүүхэд, Залуучуудад гоо зүйн мэдлэг олгох, хотын соёлд сургах, нийгэмд оролцоотой зөв зөрэг залуус болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулж буй "Super Fashion-2023" оны шилдэг шинэ залуу загвар, өмсөгч, шилдэг фото моделийг шалгаруулах улсын уралдаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилллаа. | 100% | 100% |
| **Зорилт: 1.4.1.2.** Соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | Соёлын биет болон биет бус өв уламжлагчдын судалгааг гаргах, сурталчлах, түгээн дэлгэрүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | ОНХС 10.0 сая | Соёлын биет болон биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах | Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн 3.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Музейн үзэсгэлэнгийн танхимд байрладаг 14 уран баримлын сэргээн засварлалт хийж гүйцэтгэсэн байна. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар Сяньбигийн үеийн хаад язгууртны булшийг "Орон нутгийн хамгаалалтад авах тухай асуудал"-ыг хэлэлцэж орон нутгийн хамгаалалтад авч, 2023 оны малтлага судалгааны ажлыг эхлүүлэхээр төсөв баталлаа. | 90% | 90% |
| **Зорилт: 1.4.1.3.** Олон улсын болон улсын чанартай соёл урлагийн тэмцээн уралдаанд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | | |
| 36 | Олон улсын болон улсын чанартай соёл урлагийн тэмцээн уралдаанд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | БСУГ | ЗДНХ 1.0 сая | Уралдаан тэмцээний зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Английн Лондон хотод зохион байгуулагдсан дэлхийн аварга шалгаруулах Blackpool бүжгийн фестивальд оролцсон С.Мөнхцэцэг, О.Жамц нарт санхүүгийн дэмжлэг үзүүллээ.<br><br>Үр дүн: Олон улсын Бүжгийн фестивальд Мөөгий бүжгийн клубын бүжигчид амжилттай оролцсон. | 100% | 100% |
| **Зорилт: 1.4.1.4.** Хүүхдийн номын ордны номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | | | | | | | | |
| 37 | Хүүхдийн номын ордны номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | 2021-2024 | БСУГ ХНО | Улсын төсөв болон бусад 32.5 сая | Ном хэвлэлийг ариутгах төхөөрөмжтэй болсон байна | 2021 онд УТХО-ын 980 мян төгрөгийн санхүүжилтээр ном ариутгагч төхөөрөмж худалдан авч, 2600 номыг, 2022 онд 11531 номыг ариутган, 2023 онд Хүүхдийн номын ордны номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчлэх "Оюуны сантий" төслийг хэрэгжүүлэхэд ОНТ-ийн 10.0 сая төгрөг, Хүүхдийн номын ордны гадна цахилгаан шинэр татах ажилд ОНТ 12.5 сая төгрөг зарцуулсан. 13.1 сая төгрөгийн санхүүжилтээр бие даасан цахилгааны эх үүсвэртэй болсон. Соёлын Сайд болон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах байгуулсан гэрээний 2.5 дахь заалтын хүрээнд 10 сая төгрөгийн ном худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.<br><br>**Үр дүн:** Хүүхдийн номын ордны номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчлэхэд нийт 32,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. | 90% | 90% |
| **Зорилт: 1.4.1.5.** Музей-номын сангийн зориулалтай барилгын ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | |
| 38 | Музей-номын сангийн зориулалтай барилгын ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | БСУГ | УТХО 15.6 тэрбум | Сурч хөгжих чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөл сайжирсан байна. | Дархан сумын 14-р баг "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд соёлын үйлчилгээг иргэдэд цогц байдлаар үзүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий олон улсын стандартад нийцсэн Музей-номын сангийн цогцолборыг аймагтаа анх удаа барьж | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулахаар төлөвлөн 2021 онд барилгын зураг төсөл хийгдэж, барилгын ажил эхэлсэн. 2022 онд суурийн ажил 100% дуусаж, барилгын ажлын гүйцэтгэл 50%, 2023 онд гадна өрлөгийн ажил 65%, дотор өрлөг 55%, 3 дугаар давхар цутгал тавихад бэлэн болж ажлын явц 85%. Барилгын ажлыг "Воком Констракшн" гүйцэтгэж байна.<br><br>**Үр дүн:** Улсын төсвийн 15.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй уг цогцолборын барилгын ажлын явц 85%-тай байна. | | |
| **Зорилт: 1.4.1.6.** Үндэсний өв уламжлал, **соёлын өвийг** дэлгэрүүлэх, сурталчлах чөлөөт уран **бүтээлчдийн ур бүтээлээ тууравих** орчин **нөхцөлөөр хангахад бодлогын дэмжлэг** үзүүлнэ. | | | | | | | | |
| 39 | Үндэсний өв уламжлал, соёлын өвийг дэлгэрүүлэх, сурталчлах чөлөөт уран бүтээлчдийн ур бүтээлээ тууравих орчин нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлнэ | 2021-2024 | Урчуудын холбоо | ЗДНХ<br>1.1 сая | Чөлөөт уран бүтээлчдийг дэмжиж, соёлын өвийг таниулах, түгээн дэлгэрүүлнэ. байна. | Үндэсний өв уламжлал, соёлын өвийг дэлгэрүүлэх, сурталчлах чөлөөт уран бүтээлчдийн ур бүтээлээ тууравих орчин нөхцөлөөр хангахад бодлогын дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд "Өв соёлоо өвлөн уламжилъя" сургалтыг ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн. Тус арга хэмжээнд дунд ахлах ангийн 150 сурагчид хамрагдлаа.<br>**Үр дүн:** Уламжлалт өв соёлоо өвлөн уламжлах соёлд суралцах суралцагчдын тоо нэмэгдсэн. | 90% | 90% |
| **1.5. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**<br>**ЗОРИЛГО 1.5.1. Нийгмийн** хамгаалал, **халамжийн хүртээмжийг сайжруулна.** /Алсын **хараа-2050-ийн 2.3, МУХҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.7, АХҮЧ-3.1/** | | | | | | | | |
| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хот болон Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын 45 загвар өмсөгч оролцлоо. | | |
| 83 | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажиллах хүчнийг чадавхжуулж, нутгийн иргэдэд аялал жуулчлалын чиглэлээр боловсрол олгоно | 2021-2024 | ЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ | - | 1 удаа сургалт зохион байгуулж сурталчилна. | "Тогтвортой аялал жуулчлал" хөгжүүлэхэд гарц шийдэл эрэлхийлэх сургалт, Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөгийг "ДАРХАН 50" цогцолбort зохион байгуулж, Дугуйн холбоо, Мастер тогоочдын холбоо, Дархан Загасчлалын холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Дархан Аялал жуулчлалын холбоод, Данс дүүрэн ХХК, Sky зочид буудал, Цайны их зам ХХК өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагаар зохион байгуулан оролцлоо. | 90% | 90% |
| **Зорилт: 2.3.1.2.** Аялал жуулчлал, түүх соёлын онцлогт тохирсон шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. | | | | | | | | |
| 84 | Аялал жуулчлал, түүх соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ СХС | - | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болж, борлуулалт нэмэгдсэн байна. | Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн Европ Дарханы Инновац Энтрепренершип Төвийн бойжигч Ориентал Сэвср ХХК нь "Гарааны бизнесийн төслийн уралдаан"-ы DEMO DAY өдөрлөгт Боломжит өртөгтэй дулааны алдагдалгүй байшин чиглэлд амжилттай оролцон шилдэг гарааны бизнесээр шалгаран 20000 еврогийн санхүүжилт авлаа. Дархан хотод "Нүүдлийн соёлын олон улсын хүүхдийн зуслан" -ийн үйл ажиллагаар MNS5633:2023 стандартын дагуу эхлүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн онцлогийг дэлхийд сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зэрэг таатай нөхцөлүүд бий болох юм. | 90% | 90% |
| **Зорилт: 2.3.1.3.** Орон нутгийн онцлог, нөөц боломжид тулгуурлан аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 85 | Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, дотоодын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 2021-2024 | БОАЖГ | - | Дотоодын аялал жуулчлалын тоог нэмэгдүүлэх | "Маргаашийн хот" форум, "Дархан 88" дугуйн уралдаан, "SUPER FASHION-2023" улсын уралдаан, Сэлэнгэ, Орхон аймгийн сумдын туршлага солилцох уулзалт, "VIVANT" олон ангит уран сайхны киноны зураг авалт хийгдсэн зэрэг орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагаануудын нөлөөгөөр жуулчдын тоо өмнөх жилүүдтэй харьцуулахад дотоод аялагчид 3000-аар, гадаад аялагчдын тоо 100-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.4. ЭРЧИМ ХҮЧ** | | | | | | | | |
| **ЗОРИЛГО 2.4.1. Төвлөрсөн дулаан хангамжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, айл өрхийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.** | | | | | | | | |
| **Зорилт: 2.4.1.1.** Дархан сумын гэр хорооллын айл өрхүүд рүү төвлөрсөн инженерийн шугам сүлжээ шинээр татах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 86 | Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ. | 2021-2024 | Аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | УТХО 7.6 тэрбум<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төсөл 1.0 тэрбум | Гэр хорооллын айл өрхүүдийн амьдрах орчин нөхцөл сайжирна. | 15 дугаар багийн Хабитат, Мангирт хэсгүүдийн 7 байршилд дулаан хангамжийн 2 дугаар контур татах өрлөгийн ажил дууссан.<br>Гадна бохирын ажлыг "Грийн хейд инженеринг" ХХК УТХО 7.6 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэж байна.<br>**Гүйцэтгэл 90 хувьтай.**<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төслийн хүрээнд "Дархан сумын 5 дугаар багийн Хүнсчдийн арын хэсэг, 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгойн хэсгийн гэр хорооллын 1113 айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох чиглэлийн зураг төсвийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх" төслийг хэрэгжүүлж байна. | 90% | 90% |
| 87 | Тосгон чиглэлийн гадна дулааны шугам шинээр татаж, төвлөрсөн шугамд холбоно. | 2020-2021 | Аймгийн ЗДТГ | УТХО 1.1 тэрбум | Төвийн дулааны шугамд холбогдсон байна | 1, 2, 3 дугаар багт байрлах Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, багийн төвийн байруудыг 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны шугамыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг "ДДС" ТӨХК, "Дархан-Ус суваг" ХК хийж гүйцэтгэлээ. | 100% | 100% |
| **Зорилт: 2.4.1.2.** Хороолол доторх болон гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 88 | Дархан сумын орон сууцны хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. | 2021-2023 | Аймгийн ЗДТГ | ОНХС 3.5 тэрбум төгрөг | Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг нэмэгдсэн байна | 9, 10, 11, 12 дугаар багуудын төв зам дагуу 2 толгойтой төмөр шонтой 156 гэрэлтүүлгийг "Ингүүмэл эрчим" ХХК хийж гүйцэтгэлээ.<br>Хотын төвийн авто зам дагуу 850 гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил 3.5 тэрбум төгрөгөөр хийгдлээ. | 100% | 100 |
| 89 | Гэр хорооллын гудамж зам талбайд гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ | 2021-2024 | Аймгийн ЗДТГ | Австри улсын хөнгөлттэй зээл 15.4 тэрбум | Гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдсэн байна | Хотын гэрэлтүүлэг төслийн хүрээнд гэр хорооллын багуудад нийт 5460 гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1 дүгээр багт 402, 6, 7 дугаар багт 900, 8 дугаар багт 364, 10 дугаар багт 25 дугаар хороололд 35, 13 дугаар багт 34, Малчин багт 114 гэрэлтүүлэг. Гүйцэтгэл 90 хувьтай. | 90% | 90% |
| **2.5. ЗАМ, ТЭЭВЭР, ЛОЖИСТИК** | | | | | | | | |
| **ЗОРИЛГО 2.5.1. Орон нутгийн чанартай авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /АХҮЧ 4.4.1/** | | | | | | | | |
| **Зорилт: 2.5.1.1.** Дархан-Шарын гол чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох ажлыг хийж гүйцэтгэнэ. | | | | | | | | |
| 90 | Дархан-Шарын гол чиглэлийн авто | 2021-2024 | Зам тээврийн хөгжлийн | УТХО 7.4 тэрбум | Дархан-Шарын гол чиглэлийн авто замыг | Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай 22,3 км авто замын ажлыг 2023 онд "Анандын зам" ХХК гүйцэтгэсэн. Үүнээс Дархан сумын 15 дугаар багийн | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | замыг хатуу хучилттай болгоно. | | яам, АЗДТГ | | ашиглалтад оруулсан байна | нутаг дэвсгэрээр нийт 1,7 км авто замын ажлыг "ЗЗБ" ХХК хийж гүйцэтгэсэн | | |
| **Зорилт: 2.5.1.2.** Алслагдсан баг, суурин газруудыг авто замын сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | |
| 91 | Алслагдсан баг, суурин газруудыг авто замын сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | Аймгийн ЗДТГ, Дархан сумын ЗДТГ | ОНТ, ОНХСан, Замын сан 12.7 тэрбум | Алслагдсан баг, суурин газруудыг авто замын сүлжээнд холбох ажлыг эхлүүлсэн байна. | "Тэди" төвийн уулзвараас хуучин нисэх онгоцны буудал хүртэлх 2.8 км авто зам, явган зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 7.4 тэрбум төгрөгөөр "Түвшин гэгээ" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай.<br><br>5 дугаар баг МСҮТ-өөс Гэгээ дэлгүүрийн уулзвар хүртэлх 1.063 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам, уулзварын өргөтгөл шинэчлэлийн ажлыг 1.9 тэрбум төгрөгөөр "Түвшин гэгээ" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70 хувьтай.<br><br>Дархан сумын ЗДТГ-ын туслах уулзвараас Тосгон явах Төмөр замын гарам хүртэлх авто зам, явган замын засвар шинэчлэлтийн ажлыг 2.5 тэрбум төгрөгөөр "Цахимбар инженеринг" ХХК гэрээ байгуулсан.<br><br>Малчин багийн Хөтөл хороололд 0,851 км хатуу хучилттай авто зам ажлыг ОНТХ-ийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "ОДНД" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 40 хувьтай.<br><br>6, 7 дугаар багт 1.627 км хатуу хучилттай авто зам, явган хүний замын ажлыг "Дархан-АЗЗА" ТӨХК 2.1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай. | 90% | 90% |
| 92 | Дархан сумын 8-р багийг 1-р багтай холбосон авто замын гүүрэн гарцыг шинээр байгуулна. | 2021-2023 | Аймгийн ЗДТГ | УТХО 2.1 тэрбум | Гүүрэн гарц хийгдсэн байна. | 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох төмөр зам дээгүүрх авто замын 56.2 у/м, 12.6 м өргөнтэй гүүрний 2 дугаар үе шатны ажлыг "Биг рентал" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай. | 90% | 90% |
| **Зорилт: 2.5.1.3.** Төв авто замыг засварлан шинэчлэх, хатуу хучилттай авто замыг шинээр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 93 | Төв авто замыг засварлан шинэчлэх, хатуу хучилттай авто замыг шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ | УТХО, АОНТХО, СОНХС 8.6 тэрбум | Хороолол доторх авто замын шинэчлэл хийгдэнэ | Консулын уулзвараас DBS-ын уулзвар хүртэлх 0,479 км хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлт, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугамын хучитгал, гэрлэн дохионы ажлыг 1.9 тэрбум төгрөгөөр "Өнөр зам" ХХК "Их хотын гарц" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай. | 90% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүнсний уулзвараас Өргөө багийн уулзвар хүртэлх хоёр урсгалтай хатуу хучилттай авто зам, явган хүний зам, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 2.5 тэрбум төгрөгөөр "Шилдэг зам" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай.<br>DBS-ын уулзвараас Аюулгүйн тойрог хүртэлх 1,33 км хатуу хучилттай авто зам, явган хүний замын ажлыг 2.2 тэрбум төгрөгөөр "Цахимбар инженеринг" ХХК гүйцэтгэсэн.<br>Буян захын уулзвараас Хүнсний үйлдвэрийн хойд уулзвар хүртэлх авто зам шинэчлэлт, явган хүний зам, дугуйн замын ажлыг 2.0 тэрбум төгрөгөөр "Бурхант эко асфальт" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90 хувьтай. | | |
| **Зорилт: 2.5.1.4.** Гэр хорооллолд сайжруулсан шороон зам засварын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 94 | Гэр хорооллуудын доторх авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | ОНХС 53.3 сая | Гэр хорооллын доторх авто зам засварлах ажил 50% хийгдсэн байна | 2, 3, 7 дугаар багуудад 2.1 км сайжруулсан шороон замын ажлыг ОНХС 53.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдлээ. | 90% | 90% |
| **Зорилт: 2.5.1.5.** Орон сууцны болон гэр хорооллуудын доторх авто замыг өргөтгөх, шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 95 | Орон сууцны хорооллуудын доторх авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | ОНХС 514.0 сая | Иргэдийн амьдрах аятай таатай орчин бий болно. | 11 дүгээр багт 162 метр авто зам, 13 дугаар багийн 25 дугаар байрны гадна 140 метр авто зогсоол, Өргөө багийн 22 дугаар байрны гадна 58 метр авто зогсоолын ажлуудыг ОНХС 514.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдлээ. | 100% | 100% |
| **Зорилт: 2.5.1.6.** Шинэ Хуучин Дарханыг холбосон авто замаас 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзвар хүртэлх авто зам дагуух явган зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж байгуулна. /7-р багаас 12 багийг холбосон зам/ | | | | | | | | |
| 96 | Авто замын хөдөлгөөний эрчмийн судалгаанд үндэслэн 3 уулзварыг гэрлэн дохиотой болгоно. | 2021-2024 | АЗДТГ | Орон нутгийн төсөв 339.9 сая | Дархан сум 12-р баг 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзварын гэрлэн дохиотой болсон байна. | Консулын уулзварын дэргэдэх 4 замын уулзварыг өргөтгөн, гэрлэн дохиог шинэчлэх, Мобикомын дэргэдэх 4 замын уулзварыг өргөтгөн тойрог уулзвар болгох, Хүслийн хотхоны 4 замын уулзварыг өргөтгөх, DBS-ын 4 замын уулзварыг өргөтгөх, гэрлэн дохиог шинэчлэх, Хүнсний уулзвараас Өргөөгийн уулзвар чиглэсэн авто замыг өргөтгөл, уулзварыг өргөтгөн шинэчлэх, ажлууд тус тус хийгдлээ | 100% | 100% |
| **ЗОРИЛГО 2.5.2. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. /ЗГҮАХ 3.6.3, АХҮЧ 4.4.2/ зорилтыг нэмсэн** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт: 2.5.2.1.** Дархан сум доторх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан гэр хорооллын чиглэлд үйлчилгээг өргөжүүлнэ. | | | | | | | | |
| 97 | Гэр хороолол руу нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Аймгийн ЗДТГ | Орон нутгийн төсөв 800.0 сая | Ширээ нуруу, Мангирт, Толгойт чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэнэ. | Алслагдсан багийн хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээнд парк шинэчлэлтийг хийж 56 хүүхдийн суудалтай сурагчдын 6 шинэ автобусыг 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авлаа. | 100% | 100% |
| **Зорилт: 2.5.2.2.** Нийтийн тээврийн хэрэглийн зогсоолуудын тохижилтыг үе шаттай хийнэ. | | | | | | | | |
| 98 | Нийтийн тээврийн хэрэглийн 15 зогсоолуудын тохижилтыг хийнэ | 2021-2024 | Аймгийн ЗДТГ | Орон нутгийн төсөв 339.9 сая | Нийтийн тээврийн зогсоол стандартад нийцүүлэн тохижуулсан байна. | Тэди төвийн уулзвараас хуучин нисэх онгоцны буудал хүртэлх 2,8 км хатуу хучилттай авто зам дагуу 5 байршилд нийтийн тээврийн хэрэглийн 5 зогсоол хийгдлээ.<br><br>Консулын уулзвараас DBS-ын уулзвар хүртэлх 0,479 км хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлийн хүрээнд 1 байршилд нийтийн тээврийн зогсоол хийгдлээ.<br><br>DBS-ын уулзвараас Аюулгүйн тойрог хүртэлх 1,33 км хатуу хучилттай авто зам, явган замын ажлын хүрээнд 3 байршилд нийтийн тээврийн зогсоол хийгдлээ. | 100% | 100% |
| **2.6. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ**<br>**ЗОРИЛГО 2.6.1. Айл өрхийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /АХҮЧ 3.2.1/** | | | | | | | | |
| **Зорилт: 2.6.1.1.** "Орон сууц" аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 99 | "Орон сууц" аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2021-2024 | - | - | Иргэдийн амьдрах ая таатай орчин нөхцөл сайжирна. | Хувийн хэвшлийн байгууллагууд 17 байршилд 1793 айлын нийтийн орон сууц барьж ашиглалтад орууллаа. | 100% | 100% |
| **Зорилт: 2.6.1.2.** "Тохилог орчин-эко хороолол" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 100 | "Тохилог орчин-эко хороолол" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ. | АОНХС-1 144.0 сая<br><br>СОНХС 32.2 сая | "Тохилог орчин-эко хороолол" дэд хөтөлбөрийн эхний үе шатны ажил хийгдсэн байна. | 10 дугаар багийн 380 айлын орон сууцны зоорийн давхарт бохирын иж бүрэн засвар үйлчилгээг ОНХС 5.0 сая төгрөгөөр иргэн Н.Ганчимэг, 15 дугаар багийн 11 дүгээр цэцэрлэгийн дээвэр, сантехникийн засварын ажлыг ОНХС 7.2 сая төгрөгөөр, 16 дугаар багийн "Од" цогцолбор сургуулийн А байрны гадна дулааны шугамын засварын ажлыг 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "ДДС" ТӨХК хийж гүйцэтгэлээ. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9, 10, 11, 12 дугаар багт 2.6 км дугуйн болон явган хүний замын ажлыг "Би Ти Өү" ХХК ОНХС 144.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ | | |
| **Зорилт: 2.6.1.3.** Дархан сумын гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 101 | Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ, ДС ЗДТГ, Дархан Дахин төлөвлөлтийн газар | УТХО 750.0 сая<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төсөл 1.0 тэрбум | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, орон сууцыг ашиглалтад оруулна. | 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг "Инженер геодези" ХХК хийж гүйцэтгэлээ.<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төслийн хүрээнд 5 дугаар багийн Хүнсний арын хэсэг, 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгойн хэсгийн гэр хорооллын 1113 айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох чиглэлийн зураг төсвийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх төслийг хэрэгжүүлж байна. | 90% | 90% |
| 102 | Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж, орон сууцжуулна. | 2021-2024 | АЗДТГ, ДС ЗДТГ, Дархан Дахин төлөвлөлтийн газар | УТХО 750.0 сая | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна. | 4, 5, 6, 7, 8 дугаар багийн 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын даалгаварыг батлуулж 9 байршилд Орон сууцжуулах ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангалаа. | 100% | 100% |
| **Зорилт: 2.6.1.4.** Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган дахин төлөвлөн Орон сууцжуулах ажлыг үргэлжлүүлнэ. | | | | | | | | |
| 103 | Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | АЗДТГ, Дархан сумын ЗДТГ, Дархан Дахин төлөвлөлтийн газар | УТХО 750.0 сая<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төсөл 1.0 тэрбум | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, орон сууцыг ашиглалтад оруулна. | 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг "Инженер геодези" ХХК хийж гүйцэтгэлээ.<br>Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төслийн хүрээнд 5 дугаар багийн Хүнсний арын хэсэг, 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгойн хэсгийн гэр хорооллын 1113 айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох чиглэлийн зураг төсвийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх төслийг хэрэгжүүлж байна. | 70% | 70% |
| **Зорилт: 2.6.1.5.** Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг бодлогын хүрээнд дэмжиж ажиллана. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 104 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бага өртөгтэй орон сууцаар иргэдээ хангах ажлыг бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | АЗДТГ, Дархан сумын ЗДТГ | - | Бага өртөгтэй орон сууцаар иргэдээ хангах ажлыг бодлогоор дэмжсэн байна | 2023 онд төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд орон сууцны зориулалтаар 3 байршилд 51600 м.кв газрыг үнэгүй олгож бага өртөгтэй орон сууц барих боломжоор хангалаа. Үүнд:<br><br>Нэгдсэн эмнэлэг - 800 м.кв<br>Дархан дулааны сүлжээ ТӨХК - 800 м.кв<br>Дарханы Төмөрлөг үйлдвэр ТӨХК - 50000 м.кв | 100% | 100% |
| **ЗОРИЛГО 2.6.2. Инженерийн хангамжтай орон сууц, хувийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 6.2.8/** | | | | | | | | |
| **Зорилт: 2.6.2.1.** Дархан сумын гэр хорооллын багуудын зарим хэсгийн гэр хорооллыг хувийн орон сууц, нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 105 | Хувийн орон сууцыг төлөвлөсөн, инженерийн дэд бүтцэд үе шаттайгаар холбоно. | 2021-2024 | АЗДТГ, ГХБХБГ | - | 23, 25 дугаар хороолол, 8 дугаар баг Нарантолгойн айл өрхүүд холбогдоно | 9,10 дугаар багт байрлах 23, 25 дугаар хороололд 166 өрх, 8 дугаар баг, Нарантолгой хэсэгт 36 өрх нийт 202 өрх инженерийн шугам сүлжээнд холбогдлоо. | 100% | 100% |
| **ЗОРИЛГО 2.6.3. Хот, суурины үерийн далан суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /АХҮЧ-4.4.6/** | | | | | | | | |
| **Зорилт: 2.6.3.1.** Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна. | | | | | | | | |
| 106 | Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэн байнгын ашиглалтад оруулна. | 2021-2024 | ХШҮДАХ БХБЯам, "МОН 3244/3245 төсөл" Удирдах нэгж | Азийн хөгжлийн банк "МОН 3244/3245 төсөл" 12.9 тэрбум | Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийн дахин ашиглалт хувиар нэмэгдэнэ | Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд 41 барилга байгууламжийн шинэчлэл хийгдэхээс 23 барилгын ажил дуусаж, 15 барилгын ажил үргэлжлэн хийгдэж, 3 барилгын ажил эхлээгүй байна. Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 95%-тай байна.<br>Барилга угсралтын ажлын явцын гүйцэтгэл:<br>•Үндсэн барилга угсралтын ажил: 95%<br>•Барилгын гадна дотор засал: 90%<br>•Процессын шугам хоолой угсралт: 85%<br>•Механик тоног төхөөрөмж угсралт: 85%<br>•Агааржуулалт салхивч угсралтын ажил: 98%<br>•Гэрэлтүүлэг, холбоо дохиолол угсралт: 85%<br>•Буцаан дүүргэлт газар шорооны ажил: 90%<br>•Тоног төхөөрөмжийн худалдан авалт: 87% | 90% | 90% |
| **Зорилт: 2.6.3.2.** Төв суурин газрын үерийн ус зайлуулах далан сувгийг цэвэрлэж, сэргээн засварлах ажлуудыг зохион байгуулна. | | | | | | | | |
| 107 | Төв суурин газрын үерийн ус зайлуулах далан сувгийг засварлах ажлыг үе шаттай гүйцэтгэнэ. | 2022-2024 | Аймгийн ЗДТГ | Улсын болон ОНТХ 3.6 тэрбум | Дархан сумын 9, 12, 15 дугаар багийн үерийн бетон доторлогоотой далан, | 9, 12 дугаар багийн нутаг дэвсгэр 25, 31 дүгээр хорооллын үерийн хамгаалалтын төв сувгаас хойш 216 метр урттай, угсармал бетон хавтан доторлогоотой сувгийг ОНТХ-ийн 210.0 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууламж засварын ажлыг хийсэн байна. | 15 дугаар багийн нутаг дэвсгэрт үерийн ус зайлуулах барилга байгууламжийн 3 багц ажил хийгдэж дууссан. Үүнд:<br>• "Багц 1" үерийн усны хамгаалалтын 1608 у/м сувгийн ажлыг "Баганадант" ХХК гүйцэтгэсэн.<br>• "Багц 2 үерийн хамгаалалтын төв суваг хүртэл 1817 у/м төмөр бетон хавтан доторлогоотой үерийн ус дамжуулах суваг ажлыг "Тэсийн бүрд" ХХК гүйцэтгэсэн.<br>• "Багц-3" үерийн усны хамгаалалтын ил суваг-360м, далд суваг, гүүр-224 метр нийт 584 метр сувгийн ажлыг "БЭЗБ" ХХК гүйцэтгэсэн.<br>Дархан суманд 4009 метр шинээр нэмэгдэж үерийн усны эрсдлээс урьдчилан сэргийлэх, найдвартай ажиллагаа хангагдсан. | | |
| **Зорилт: 2.6.3.3.** Гэр хорооллын ундны усны шинэ эх үүсвэрийг бий болгох, одоо байгаа зөөврийн худгуудыг ухаалаг системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ | | | | | | | | |
| 108 | Зөөврийн усан санг төвлөрсөн шугамд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | ОНХС 369.3 сая | 3, 8, 15, Малчин багийн нутаг дэвсгэрт шинээр ашиглалтад орсон худгийг ухаалаг тоолуурт шилжүүлэх | 3, 8, 15, Малчин багуудын нийт 14 худгийн засвар шинэчлэлийн ажил, ухаалаг системд холбох шинэчлэх ажлыг ОНХС 369.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эйч Ти Эл" ХХК, "Эко энержи ресорс" ХХК хийж гүйцэтгэлээ. | 100% | 100% |

*6 дэд бүлэг, 34 зорилт, 47 арга хэмжээ*

## ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

**ЗОРИЛГО:** **Ногоон бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй олон нийтийн үйл ажиллагааг дэмжиж, байгалийн дурсгалт газар түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах, хамгаалах, сурталчилах ажлыг нэмэгдүүлнэ.**

| Д/д | ЗДҮАХ-ын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/ | Зорилтот түвшин, үр дүн /Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он | | % тухай жилээр | % 4 жилээр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн /Хэрэгжилт/ | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **3.1. ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**<br>**ЗОРИЛГО 3.1.1. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, "Түгжрэлгүй төрийн үйлчилгээ"-г нэвтрүүлнэ. /"Алсын хараа-2050"-ийн 5.2.4, 5.3.1, 5.3.3, 5.3.4, МУХҮЧ-5.3.4, 5.4.5, ЗГҮАХ-4.1.3, 4.1.4, АХҮЧ-5.1.1/** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт: 3.1.1.1.** Төрийн үйлчилгээний нэгдсэн систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна. | | | | | | | | |
| 109 | 70371313 нээлттэй утсыг тогтмол ажлуулах, 1-16, Өргөө, Малчин багуудыг оператортой болгож байнгын ажлын байрыг бий болгоно. | 2021-2024 | ДСЗДТГ | ДСЗДТГ-ын төсөв 400,0 мян | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн цаг хугацаа, чанар сайжирч багийн төвүүд нээлттэй утастай болсон байна. | 2024 онд 1-16, Өргөө, Малчин багуудад нийт 2778 Өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч 2575 буюу 98%-ийг шийдвэрлэсэн. Шийдвэрлэх шатандаа явж буй 138 өргөдөл, гомдол байна. Үүнээс: бичгээр 2450 Утсаар хандсан-940 /1-16, Өргөө, Малчин багууд 7037-2001-7037-2018 Иргэдийн санал, гомдол хүлээн авах суурин утастай болсонтой холбогдуулан 1203 /1-8 сар хүртэлх 9-12 сарын хугацаанд 650 өргөдөл хүлээн авч холбогдох харьяа болон мэргэжлийн байгууллагуудад уламжлан тухай бүрд нь шийдвэрлэсэн. /Биечлэн уулзсан- 540 / Хүсэлт 1250 88,7% Санал 723-9,07%. Гомдол 172 2,2%/ | 100% | 100% |
| **Зорилт: 3.1.1.2.** Төрийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 110 | Төрийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны стандартын хэрэгжилтийг байнга сайжруулна. | 2021-2024 | ДСЗДТГ | ОНТХО 20,0 сая | ISO-9001:2016 нэвтрүүлэх санхүүжилтийг төсөвт суулгасан байна. | Зөвлөх үйлчилгээний "Оргил эрдэм үндрах" ХХК-тай хамтран үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах байгууллагын соёлыг бий болгон байгууллагын үр ашиг, үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг Засаг даргын Тамгын газар болон 1-16, Өргөө, Малчин багт нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. | 70% | 70% |
| **ЗОРИЛГО 3.1.2. Шийдвэр гаргахад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ. /"Алсын хараа-2050"-ийн 5.2.4, МУХҮЧ-5.1.3, ЗГҮАХ-4.2.10, АХҮЧ-5.2.1/** | | | | | | | | |
| **Зорилт: 3.1.2.1.** Иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх, санал авах үйл ажиллагааг олон талт хэлбэрээр зохион байгуулна. | | | | | | | | |
| 111 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран "Иргэний боловсрол"-ын чиглэлээр нэвтрүүлэг, сургалт сурталчилгааг зохион байгуулна. | 2021-2024 | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, Дархан сумын ХМА | Дархан сум 30.0 сая төгрөг | "Иргэний боловсрол"-ын чиглэлээр 15 нэвтрүүлэг, сургалт сурталчилгааг зохион байгуулна. | Орон нутгийн RGB тв, DBS тв, Дуут үзэг ТББ, Монцамэ агентлаг, Эхлэл радио ФМ 87.9, NTV тв, Үндэсний тв MNB, ФМ 89.5 гэсэн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, эрх зүйн сургалт, мэдээлэл, соён гэгээрүүлэх зурагт хуудас, шторк, реклам, сонгогл /радио зөвлөгөө/, авилгын сэрэмжлүүлэг зэрэг 35 төрлийн мэдээ мэдээллийг 250 удаагийн давтамжтайгаар иргэдэд хүргэсэн. Мөн өрхийн аж ахуй эрхлэгч иргэдэд "Бизнесээ эхэл хөгжүүл" сэдэвт сургалтыг 3 удаа зохион байгуулж иргэдийг мэдээ мэдээллээр хангалаа. | 100% | 100% |
| 112 | Иргэдээс цахим орчинд санал авах үйл ажиллагааг идэвхжүүлнэ |  | 1-16, Өргөө, Малчин багууд, Дархан | - | Иргэдийн оролцоо нэмэгдэж, төр иргэний хамтын эргэх холбоо сайжирсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг жил бүрийн 6 сарын 30-ны өдрийг дуустал цахимаар болон цаасаар хүлээн авахад 100 гаруй иргэн саналаа цахим хэлбэрээр ирүүлсэн. "Иргэдийн индэр" нээлттэй хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 240 гаруй иргэн санал хүсэлтээ | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сумын ХМА | | | цахимаар ирүүлж, холбогдох шийдвэрийг гарган, санал хүсэлтийг шийдвэрлэлээ.<br>Дархан сумын "Санал хүсэлт" цахим хаягаар 168 иргэн санал, хүсэлт, гомдол ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэн ажилллаа. | | |
| **Зорилт: 3.1.2.2.** Төрийн зарим чиг үүрэг /хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт/-ийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ. | | | | | | | | |
| 113 | Төрийн зарим чиг үүрэг /хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт/-ийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, иргэн, ТББ-ын оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | СЗДТГ | ЗДТГ-ын төсөв 2,5 сая | Иргэд, ТББ-ын оролцоо нэмэгдэж, эргэх холбоо сайжирна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан "Дархан спорт ордон"-ы үйл ажиллагааг "Дархан хүчтэн клуб" ТББ-т шилжүүлэн иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Уг ордонд 6 төрлийн спортын дугуйлан, сургалт явагдаж, 172 иргэн, хүүхэд багачууд хамрагдаж байна. 2023 онд 10 төрлийн арга хэмжээ 158 удаа зохион байгуулагдаж 5000 гаруй баг тамирчид оролцсон байна.<br>Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу ТББ-ын 3 төлөөлөлтэй хамтран Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа сургалт мэдээллийг зохион байгуулж ажилласан.<br>Мөн сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавих санал асуулгыг "Гэрэлт эрдэм цацрах" ТББ-аар гүйцэтгүүлэн 2026 иргэнээс санал авлаа. | 100% | 100% |
| ЗОРИЛГО 3.1.3. **Төрийн албан хаагчдыг сурч хөгжих** орчныг **бүрдүүлж**, мэдлэг, **чадварыг** дээшлүүлэн, тогтвор суурьшилтай **ажиллуулна. /"Алсын хараа-2050"**-ийн **5.4.4, МУХҮЧ-5.4.2, 5.4.4, ЗГҮАХ-4.2.6, АХҮЧ- 5.3.1, 5.2.3/** | | | | | | | | |
| **Зорилт: 3.1.3.1.** Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулна. | | | | | | | | |
| 114 | Сум, багийн албан хаагчдыг мэргэших, чадавхжуулах сургалтуудад үе шаттайгаар хамруулна. | 2021-2024 | СЗДТГ | ЗДТГ-ын төсөв 2,5 сая | Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилнэ. | МУЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Удирдлагын академийн захирал нарын хамтарсан тушаалын дагуу 2021-2024 онд мэргэшүүлэх дунд хугацааны сургалт-11, давтан сургалт-1, ахлах түшмэлийн сургалтад – 1, эрхэлсэн түшмэлийн сургалтад - 1 шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт-5 албан хаагчийг хамрууллаа. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт 56 удаагийн сургалтад давхардсан тоогоор 120 албан хаагч хамрагдлаа.<br>Мөн удирдлагын академийн зорилтод 13 төрийн сургалтад давхардсан тоогоор 117 албан хаагч хамрагдсан. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 115 | Байгууллагын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | СЗДТГ | ЗДТГ-ын төсөв 4,1 сая | Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилнэ. | МУЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Удирдлагын академийн захирал нарын хамтарсан тушаалын дагуу 2021-2024 онд мэргэшүүлэх дунд хугацааны сургалт-13, давтан сургалт-1, ахлах түшмэлийн сургалтад – 4, эрхэлсэн түшмэлийн сургалтад - 1 шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт-8 албан хаагчийг хамруулллаа. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдсан 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 168 албан хаагчийг хамрууллаа. Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 сургалтуудад 191 албан хаагч, Архив бичиг хэрэг хөтлөлтийн сургалтад -4, Алсын хараа 2050 сургалатад 86, Чадамжид суурилсан хүний, нөөц, сургалтад – 1, Дизайн сэтгэлгээ сургалтад -1, дотоод аудитын бэлтгэх сургалтад -7, Худалдан авах ажиллгааны А-3 сургалтад -9, удирдлагын академийн зорилтод 15, нийт сургалтад давхардсан тоогоор 509 албан хаагч хамрагдсан. | 100% | 100% |
| **Зорилт: 3.1.3.2.** Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулна. | | | | | | | | |
| 116 | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | СЗДТГ | ЗДТГ-ын зардал 344,7 сая | Төрийн албан хаагчдын тав тухтай орчинд ажиллах нөхцөл бүрдэнэ. Техник хангамж нэмэгдэнэ. Хөдөлмөрийн бүтээмж өснө. | Эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, сум, аймаг, салбар, төрийн дээд одон медалиар шагнагдсан 6 албан хаагчид шагналд дагалдах мөнгөн урамшуулалд 1.5 сая төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарсан 8 албан хаагчид 77,2 сая төгрөг, шинээр хүүхэдтэй болсон 25 албан хаагчаар гэрийн гачигдал тохиолдсон 9 албан хаагч, эрүүл мэндийн шалтгаантай 1 албан хаагчид нийт 38,6 сая төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.<br>Баг, сумын ЗДТГ-ын урсгал засвар, тохижилт үйлчилгээнд 63,1 сая төгрөг, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж зөөврийн компьютер, автомашины засвар үйлчилгээнд 21,8 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын хурлын заал 82,8 сая, Хүлээлгийн өрөө, коридор 84,6 сая, ариун цэврийн өрөө 25,6 сая, Хурлын заалны тоног төхөөрөмж 55,2 сая төгрөгийн тендер зарлан шалгаруулж завсар шинэчлэлийн ажлыг хийлээ. 2024 онд 37.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шинэчлэж албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулсан.<br>-ЗДТГ-ийн 2 давхарын их засварт 380 сая.төгрөг<br>- Камер, компьютер тоног төхөөрөмж-150 сая.төгрөг | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Тавилга, эд хогшил 163 сая төгрөг зарцуулсан байна.<br>- Дархан сумын Засаг даргын Тамгын газар нь хурлын танхим, хүлээлгийн өрөө, үүдний өрөө, 00-ийн засвар, 11, 12 дугаар багийн төвийн байрны хурлын танхим, малчин багийн цахилгаан халаагуур, агуулах зэргийг 265.128 сая төгрөгөөр засч сайжруулсан.<br>2021-2024 онд 1.128.428,000 төгрөгийг зарцуулсан байна.<br>Засаг даргын Тамгын газар болон багийн 108 албан хаагчдаас "Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамж" санал асуулгыг авахад: нийт албан хаагчдын 90.0% байгууллагынхаа дотоод уур амьсгалд сэтгэл ханамжтай, 50.0% нь ажлын байранд сурч хөгжих, боломж дунд зэрэг, 97.2% нь энэ байгууллагад ажилладагтаа сэтгэл ханамжтай, 92.0% нь хамт олноосоо ажиллах хүсэл эрмэлзэл авдаг буюу мотивацждаг, 50.0% тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх шаардлагатай, 63.0% өрөөний тохижилт хийх шаардлагатай, 30.0% нь эрүүл ахуй, цэвэр орчныг бүрдүүлсэн гэж тус тус хариулсан байна. | | |
| 117 | Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллага бүр "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021-2024 | СЗДТГ | - | Төрийн албаны тогтвортой байдал бий болно. | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 4 жилээр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Албан хаагчдын эрхлэх чиг үүрэг, ажлын ачааллыг бууруулах бууруулах зорилтын хүрээнд шинээр 10 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.<br>Төрийн албаны жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтын зарыг нийт 56 удаа зарлуулах хүсэлтээ салбар зөвлөлд хүргүүлэн сонгон шалгаруулалт зарлуулж 41 албан хаагч төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон. | 100% | 100% |
| **ЗОРИЛГО 3.1.4. Гадаад улс орнуудын найрамдалт муж, хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ. /ЗГҮАХ-4.5, АХҮЧ-5.2.2/** | | | | | | | | |
| **Зорилт: 3.1.4.1.** Ах дүү, шууд харилцаат хотуудтай эдийн засаг, нийгэм, соёл, спорт хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 118 | Урьд тогтоосон гадаад харилцааг бэхжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 2021-2024 | Сумын ЗДТГ | - | Гадаад харилцаа сайжирна. | Сумын гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр АНУ, БНХАУ, БНЭУ-ын ЭСЯ-ууд, Тайпэйн Худалдаа, Эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлаар Японы ЭСЯ-тай ярилцлага зохион байгуулж, Кристина Ноблийн Хүүхдийн сан, "Вэлүү" сангийн төлөөлөгчидтэй мөн чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцов. Япон Улсын Ибараки муж, АНУ-ын Денвер хотуудтай ах дүүгийн харилцаа тогтоох бэлтгэл ажлыг хангаж байна. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нутгийн удирдлагын байгууллагын чадавхыг сайжруулах, сайн засаглалыг бэхжүүлэх чиглэлээр НҮБ, Европын Холбооны "НАЛАС" байгууллага, "Найрамдал" төсөлтэй хамтран ажиллах, харилцан туршлага солилцов. Монгол Улсад анхдагч болох дэлхийн жишигт нийцсэн эзэнгүй амьтдыг түр байрлуулан асрамжлах төв, гэрийн тэжээвэр амьтдын өдөр өнжүүлэх, үрчлүүлэх төв, мал эмнэлгийн цогцолборын төслийг АНУ-ын ОУ-ын хөгжлийн агентлаг, АНУ-ын Төрийн Департаментын харьяа Америк-Хятадын харилцааны Үндэсний хорооны төлөөлөгчдөд танилцуулсан бөгөөд ОУБ-уудын хандив, санхүүгийн тусламжаар дээрх нэгдсэн цогцолборыг байгуулах 10 тэрбум төгрөгийн өртөгтэй төслийн яриа хэлэлцээ үргэлжилж байна. Уг төсөл хэрэгжсэнээр эзэнгүй амьтдыг устгах уламжлалт буюу харгис хэрцгий аргыг бүрмөсөн халж, тоо толгойг нь хяналтад авч, халдвар өвчин тархахаас сэргийлэх боломж бүрдэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл хангагдахаас гадна иргэдийн асран хамгаалалтад буй гэрийн тэжээвэр амьтдад цогц үйлчилгээ үзүүлэх юм. | | |
| **Зорилт: 3.1.4.2. Статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв, ил тод, хараат бус, бие даасан зарчмыг хангуулж ажиллана.** | | | | | | | | |
| 119 | Статистик бүртгэл мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг сайжруулна | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | - | Хэрэглэгч хэрэглээт мэдээллийг нэг дороос, түргэн шуурхай авна. | "ХАӨМС-ын алдаа засварлах, мэдээлэл баяжуулалт хийхийн ач холбогдол", "Хөдөө аж ахуйн программын уялдаа холбоо" сэдвүүдээр аймгийн Статистикийн газрын мэргэжилтнүүдтэй хамтран сургалт хийж 1-16, Өргөө, Малчин багийн нийт 55 албан хаагчийг сургалтад хамрууллаа. | 100% | 100% |
| 120 | Дархан сумын хүн ам, өрхийн бүртгэл мэдээллийн цахим сангийн баяжилтыг хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг тогтмол зохион байгуулна. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | - | Зөрчил арилсан байна. | Мэдээллийн санд тогтмол шинэчлэлт хийж, дараах зөрчил дутагдлыг арилгалаа. Үүнд: Оршин суугаа хаяг байршил, орон сууцны төрөл зэрэг хувь хүний 31 төрлийн үзүүлэлтийг 2216 алдааг засаж, мэдээллийн сангийн нийт 68051 суурин хүн амын мэдээллээс 25230 иргэний мэдээллийг шинэчиллээ. | 100% | 100% |
| 121 | Дархан сумын Нийгэм, Эдийн Засгийн байдлын үндсэн үзүүлэлтүүдээр мэдээлэл бэлтгэж олон нийтэд тогтмол мэдээллэнэ. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | - | Чанар хүртээмж нэмэгдэнэ. | Жилд 1 удаа 8 төрлийн 196 үзүүлэлтээр баяжилт хийж байна. Үүнд: Хүн ам нийгмийн байдал, Эрүүл мэнд, Боловсрол, Мал аж ахуй, Газар тариалан, Нийгмийн зарим үзүүлэлт, Гэмт хэрэг, Ажилгүйчүүд зэрэг мэдээ мэдээллүүдийг тоон болон график, хүснэгтэн үзүүлэлтээр программаас гаргадаг болголоо. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 122 | Статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | Статистикийн хэлтэс 719.2 мян Дархан сумын ЗДТГ 2.8 сая | Албан ёсны статистик мэдээний боловсруулалтыг иргэн, өрх, аж ахуйн нэгжүүдтэй холбоотой байж үнэн зөв бүрэн хамралттайгаар гаргаж, мэдээллийн бааз бий болно | Улсын хэмжээний үндсэн 7 төрлийн тооллого, судалгаа болон статистикийн 16 төрлийн судалгаа, мэдээллийг боловсруулж мэдээллийн бааз үүсгэн ажиллаж байна.<br>- Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаанд 49 өрх, 1 ААНБ хамрагдан 1600 тоо толгой мал тоологдлоо. Үүнээс: Адуу-376, үхэр-707, хонь-239, ямаа-278 байна.<br>- Нийт 165,21 га-д тариалалт хийж 1853.02 тн хураалт хийлээ.<br>Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 9-12 дугаар саруудад явагдаж, 270 өрх хамрагдлаа. | 100% | 100% |
| **3.2. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО**<br>ЗОРИЛГО **3.2.1. Гамшиг ослоос урьдчилан** сэргийлэх, эрс**длийг бууруулах арга хэмжээг** төлөвлөн хэрэгжүүлж, **батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.** | | | | | | | | |
| Зорилт: **3.2.1.1.** Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах зорилгоор олон нийтэд тулгуурласан удирдлагын тогтолцоог, нэвтрүүлэн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ. | | | | | | | | |
| 123 | "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх" төсөл | 2021-2024 | Сумын ЗДТГ, ОБГ | ОНТХО 94,3 сая | Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх нөхцөл сайжирна. | Гамшгаас хамгаалах дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх ажлыг хүрээнд "Их зэвэг" ХХК-тай гэрээ байгуулж, 6 байршилд хийж гүйцэтгэсэн.<br>Зарлан мэдээллийн дуут дохионы хэвийн үйл ажиллагаар Онцгой байдлын газрын мэдээлэл шуурхай удирдлагын хэлтэс хангаж 2023 оны хэмжээнд 4 удаа ашигласан байна. | 100% | 100% |
| Зорилт: **3.2.1.2.** Гамшгаас хамгаалах материаллаг баазыг нэмэгдүүлж, гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлын чадавхийг сайжруулна. | | | | | | | | |
| 124 | Гамшгаас хамгаалах материаллаг баазыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Сумын ЗДТГ, ОБГ | ОНТХО 36,5 сая | Туулах чадвартай автомашинтай болно. | Дархан сумын Гамшаагс хамгаалах Еренхий зориулалттай мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж, гамшгийн үед авч хэрэгжүүлэх дадлага сургуулийг 2 удаа зохион байгууллаа.<br>Онцгой байдлын газар туулах чадвар сайтай УАЗ Фургон маркын автомашиныг 36,5 сая төгрөгөөр (2021 он), Соната-7 маркын автомашиныг 17,95 сая төгрөгөөр 2020 онд тус тус нийлүүлсэн. | 100% | 100% |
| **Зорилт: 3.2.1.3.** Цэргийн алба хаах зөвшөөрөгдсөн хэлбэрүүдийг зохистой хэрэгжүүлж, иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулж ажиллана. | | | | | | | | |
